УРИЛГАТ ӨГҮҮЛЭЛ

# Тайж Хайрханы Тунхаглал

## НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын (UNCCD) Талуудын бага хурлын 17 дугаар чуулган (COP17)-д өргөн барив. Улаанбаатар, Монгол улс, 2026 он

Удиртгал

*НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын (UNCCD) Талуудын бага хурлын 17 дугаар чуулганы (COP17) үеэр нийгмийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаачид, малчид, мэргэжилтнүүдээс бүрдсэн олон улсын 65 төлөөлөгч Монгол Улсын Тайж хайрханд цугларан нүүдлийн мал аж ахуйн ирээдүйн талаар хэлэлцэж, соёлын эрх, мэдлэгийн өвлөл, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэх*

Nomadic Studies Дугаар 33 (2026): Нүүдлийн ирээдүй (2026). Published by the International Institute for the Study of Nomadic Civilizations under the auspices of UNESCO. This work is licensed under Creative Commons Attribution-ShareAlike 4.0 International.
https://doi.org/10.67086/6y4nhc75

*чадавхыг хангахад чиглэсэн зөвлөмжийг гаргалаа. Нүүдэллэх үйл явц болон түүнийг дэмждэг институцүүд нь бэлчээр-мал аж ахуйн тогтолцооны эрүүл мэндэд нэн чухал бөгөөд тэдгээрийг цогцоор нь санхүүжүүлэх шаардлагатай гэдэгт бид санал нэгдсэн. Энэ зорилгоор хамтын хүчээр 10 уриалга бүхий энэхүү Тунхаглалыг боловсруулан гаргав.*

Бид, Монгол улсын Тайж хайрхан уулын бэлд ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн зохион байгуулсан “Нүүдлийн ирээдүй: Соёлын эрх, мэдлэгийн тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэхүй” хуралд оролцсон эрдэмтэн судлаачид, малчид, мэргэжилтнүүд,

Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчдийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, “Олон улсын бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жил” (2026)-ийг тэмдэглэж буйг сайшааж;

Уугуул иргэдийн газар нутаг, өвөрмөц соёлын бүлэг, тэр дундаа нүүдэлчдийн хувьд нүүдэллэх туршлагадаа үндэслэн өөрсдийгөө тодорхойлох эрх, уламжлалт нутаг дэвсгэрийн эрхийг баталгаажуулсан НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн тухай тунхаглал (UNDRIP, 2007)-ын зарчмуудыг дэмжиж;

НҮБ-ын Нүүдэлч уугуул иргэдийн асуудал хариуцсан тусгай илтгэгчийн 2024 оны тайлан,[1] Тэмээн аж ахуйн талаарх 2024 оны Сарди олон улсын зөвлөгөөн,[2] Соёлын эрхийн тухай 2007 оны Фрибургийн тунхаглал,[3] ЮНЕСКО-ийн Соёлын олон төрөл зүйлийн тухай түгээмэл тунхаглал (2001),[4] Нүүдэлчид ба байгаль хамгааллын тухай Дана тунхаглал (2002)[5] болон Дана манифест (2022),[6] Нүүдэлчдийн амьд өвийг хамгаалах тухай Улаанбаатарын тунхаглал (2023), Нүүдэлчдийн ёс зүй ба соёл хоорондын яриа хэлэлцээний (2024)-ны тухай мэдэгдэл,[7] Залуу малчдын дэлхийн тунхаглал (2026),[8] Малчин эмэгтэйчүүдийн Катманду тунхаглал (2026),[9] Тогтвортой бэлчээрийн эрхийн төлөөх нүүдэлчдийн улаан шугам санаачилга (2026)[10] зэрэг баримт бичгүүдийг

эргэн санаж - эдгээр нь нүүдэллэх эрхийг батлан, нүүдэлчдийг газар нутгийн шүтэлцээт түнш гэдгийг баталгаажуулж байгааг тэмдэглэж;

ЮНЕСКО-ийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн “Трансхюманс- мал сүргийг улирлаар туун нүүдэллэх уламжлал” (2023), “Монголын нүүдлийн зан үйл” (2024), “Киргиз, Казах, Каракалпак угсаатны гэр барих уламжлалт мэдлэг, ур чадвар” (2025) болон нүүдлийн мал аж ахуйтай шууд холбоотой бусад 24[11] өвөрмөц соёлын илрэл, илэрхийллийг баяртайгаар хүлээн авч байна. Эдгээр нь нүүдэллэхүй болон түүнтэй холбоотой зан үйл, шүтлэг бишрэл нь зөвхөн амьжиргааны арга хэлбэр төдий биш, харин хамгаалбал зохих өв гэдгийг нотолж буйг тэмдэглэж;

Эдгээрийг үндэслэж уур амьсгалын санхүүжилтийн тодорхой салбарт өргөжүүлэн хөгжүүлэх ач холбогдлыг онцолж;

Энэхүү тунхаглалыг НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын (UNCCD) Талуудын бага хурлын 17 дугаар чуулган (COP17)-д хуран цугларсан Талуудад хандан бэлтгэв.

**Бидний илгээлт**

Уур амьсгалын өөрчлөлт болон зах зээлийн нөлөөллөөс үүдэлтэй мал аж ахуй, газар ашиглалтын өөрчлөлтүүд хавсарч нь газрын доройтлын гол шалтгаануудын нэг болдог бөгөөд агаарын хэм нэмэгдэх, хөрсний доройтол, хөрсний чийг багасах, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх, түймэр гарах, ургамал, биологийн олон янз байдал, хөрс, агаар мандалд үзүүлэх бусад нөлөөллийг үүсгэдэг. Нүүдлийн мал аж ахуй-бэлчээрийн тогтолцоо нь хүний нөлөөгөөр үүссэн уур амьсгалын эдгээр өөрчлөлтөд ихээхэн өртдөг.[12] Иймд бэлчээрийн доройтол, цөлжилт нь хөрсний хямрал төдийгүй, хүн-газар хоорондын харилцааны хямрал юм. Уугуул ахмадууд болон малчдын сургадгаар хүн-байгаль хоорондын харилцаа нь харилцан хамаарал, хариуцлагад тулгуурласан байх ёстой. Энэхүү харилцаа нь нүүдэлчдийн сургаал, зан үйл, ёслолыг багтаасан уламжлалт мэдлэг, дадлаар хэмжигдэнэ. Нүүдлийн ахуйд тулгуурлан, малчдын олон үеийн турш хуримтлуулсан

мэдлэгээр энэхүү харилцааг хадгалж ирсэн газар оронд бэлчээр эрүүл хэвээр үлдсэн. Харин нүүдлийг хязгаарлаж, зааглахад хүргэсэн буюу хориглосон газар оронд байгаль ч, түүнийг хамгаалах холбоо хэлхээ ч аль аль нь доройтжээ.

Нүүдлийн мал аж ахуй нь зөвхөн нүүдэллэхэд биш юм. Энэ нь байгаль орчны тодорхойгүй байдлыг боломж болгон хувиргах тусгай стратеги бөгөөд нөөцийг нэг дор хашиж хянахын оронд цаг хугацаа, орон зайг даган тархсан, өөрчлөгдөн буй нөөцийг дагаж нүүдэллэдэг. Хэдэн арван жилийн турш буруу чиглэсэн хөгжлийн бодлого үүнийг хоцрогдсон хэмээн үзэж, нэг газартаа суурьшсан фермерийн аж ахуйг илүү орчин үеийн хувилбар хэмээн сурталчилж ирсэн. Гэвч уур амьсгалын өөрчлөлт гүнзгийрч, хур тунадас, ган зудыг ихэсгэж байгаа өнөө үед энэхүү “орчин үежүүлэлтийн” төсөөлөл нэгэнт хоцрогджээ. Чулуужсан түлшинд тулгуурласан тогтвортой системүүд хамгийн эмзэг байгаа бол цаг уурын өөрчлөлттэй зохицон ажиллахад зориулагдсан системүүд ирээдүйд хамгийн сайн зохицох болно.

Баримт нотолгоонуудын дагуу нүүдэл суудал нь биологийн олон янз байдал ба сөрөн тэсвэрлэх чадварыг бууруулахаас илүүтэйгээр нэмэгдүүлж байдаг. Нүүдлийн мал аж ахуйд хэрэгждэг нүүдэллэх туршлага нь өргөн хэмжээндээ аль хэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги бөгөөд хүн, мал сүрэг, газрыг амьд харилцаанд байлгадаг уламжлалт туршлага мөн.

> **Тиймээс бид Талуудад хандан: малчдад хүчээр тулгасан шинээр дасан зохицох төслүүдийг санхүүжүүлэхээс илүү нүүдлийн мал аж ахуйг өөрийн төрхөөр нь хадгалан үлдээхэд чиглэсэн санхүүжүүлэлтэд шилжихэд** хэлэлцүүлгийг чиглүүлэхийг уриалж байна.

## Нүүдлийн мал аж ахуй ба нүүдлийг хүлээн зөвшөөрч, санхүүжүүлэх ёстой[13]

Бид Талуудыг хэдэн үеийн турш боловсронгуй болсон, хувьсамтгай ландшафтад зохицсон дадал зуршлын цогц болох нүүдлийн мал аж ахуйг

санхүүжүүлэхийг уриалж байна. Эдгээр дадалд сүргийн чөлөөтэй, саадгүй бэлчээрлэх олон янзын нүүдлийн хэв маягууд орно. Тухайлбал, улирал солигдоход нүүдэллэх, нүүдэл; уулын бүсэд явагддаг трансхюманс; усны цэг ба бэлчээр хооронд зорчих; тэжээл хайх, ан хийх боломжид тохирсон уян хатан сүргийн хөдөлгөөн; яаралтай, богино хугацаанд бэлчээрлэх; шүтлэгтэй уул, (овоо) усны эх, булаг шанд, худаг, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, нүүдлийн зам, үндсэн болон нөөц бэлчээрээр дамжсан бэлчээрлэлт, нүүдэл, мөн онгон дагшин газар, мөргөлийн зам болон бусад оюун санааны ач холбогдолтой газартай харилцах хөдөлгөөн зэрэг орно. Нүүдэл нь дараах хүчин зүйлсээс хамаардаг: сүргийн бүтэц; хувьсамтгай нийгэм-экологийн нөхцөлд тохирсон уян хатан үүлдэр угсаа ба сүргээ чанаржуулах боломж; цахим мэдээллийн болон сүлжээнээс гадуурх сэргээгдэх эрчим хүчний дэд бүтэцтэй холбогдох боломж; мөн тэмээ зэрэг хуурай, цөлөрхөг орчинд дасан зохицсон уугуул үүлдэр, генетик нөөцийг өсгөн үржүүлэх чадвар зэрэг багтана.

Эдгээр үйл явц болон үүнд оролцогч, дэмжигч байгууллагууд нь бэлчээр-мал ахуйн системийн эрүүл байдлыг хангахад нэн чухал тул тэдгээрийг нэгдмэл байдлаар авч үзэн санхүүжүүлэх шаардлагатай.

## Талуудад хандан уриалах нь

Бид Талуудад дараах зүйлийг хийхийг уриалж байна:

1. Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг малчдын өөрийгөө тодорхойлох эрхийг хангах чиглэлд шилжүүлж, нүүдлийн мал аж ахуйг бусад зүйлсийн зэрэгцээ үр дагавар гэж үзэлгүй шууд хөрөнгө оруулах салбар болгон дэмжих. Улирал харгалзан бэлчээр сэлгэх, тахилгат газар, ус авах эрх, засаг захиргааны хилээр дамжих нүүдлийн эрх зэргийг багтаасан уламжлалт газар эзэмшлийн эрхийг хууль ёсоор хүлээн зөвшөөрөх, тэр дундаа малчид уур амьсгалын өөрчлөлтийг зохицуулж ирсэн уян хатан, албан бус аргуудыг багтаана.
2. Уламжлалт газар эзэмших тогтолцоо, нүүдлийг бэлчээрийн эрүүл байдлын урьдчилсан нөхцөл болгон хүлээн зөвшөөрч хууль ёсны эрх

олгож, сүрэг, малчин, ландшафт хоорондын уялдааг өөрчилж, тусгаарлан хуваахгүй бүрэн бүтэн байлгах. Энэхүү эрх зүйн хамгаалалт нь зөвхөн НҮБ-ын Уугуул Иргэдийн Эрхийн Тухай Тунхаглалаар хүлээн зөвшөөрөгдсөн уугуул иргэдэд төдийгүй, олонх улсад аж төрдөг нүүдлийн амьжиргаатай цөөнхөд ч нэгэн адил үйлчлэх ёстой. Эс тэгвээс эдгээр хамгаалал нь дэлхийн нүүдэлчин малчдын ихээхэн хэсэгт хүрэхгүй хэвээр үлдэнэ.[14]

3. Уул уурхай, газар тариалан болон бусад газар ашиглалт малчдын бэлчээрт аюул учруулж байгаа тохиолдол бүрд урьдчилан мэдээлсэн, чөлөөт, мэдээллийн зөвшөөрөл (FPIC) болон нийгэм, соёл, оюун санааны нөлөөллийн үнэлгээг[15] шаардах, онгон байгаль, нүүдлийн зам сүйдэхийг ямар ч эдийн засгийн нөлөөгөөр нөхөж баршгүй хохирол хэмээн хүлээн зөвшөөрөх. Урьдчилсан, чөлөөт, мэдээллийн зөвшөөрөл нь зөвшөөрөл өгөхгүй байх эрхийг агуулах бөгөөд уг татгалзал эцсийн шийдвэр байна.
4. Малчин иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэх, дахин суурьшуулах, суурин болгохыг хориглох. Учир нь нүүдэлчдийн соёл, туршлага, мэдлэгийн тогтолцоо нь тодорхой ландшафт- тухайлбал, бэлчээр, усны эх, нүүдлийн зам, онгон байгальд холбогдох бөгөөд эдгээр холбоог хэчнээн санхүүгийн дэмжлэгтэй ч бусад газарт нүүлгэн шилжүүлэх, дахин байгуулах боломжгүй юм. Ямар ч сэргээн засварлах төсөл, байгаль хамгааллын эрх, олборлолтын зөвшөөрөл, нөхөн олговор эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицуулах хөтөлбөр нь малчдыг нутаг дэвсгэрээс нь нүүлгэх нөхцөлтэйгээр хэрэгжиж болохгүй.
5. Нүүдлийн мал аж ахуйг хүн ба байгалийн тогтвортой байдлын үндсэн суурь хэмээн хүлээн зөвшөөрч, санхүүжүүлэх. НҮБ-ын конвенцууд болон түүний механизмуудаар дамжуулан мал аж ахуйтай холбоотой уламжлалт мэдлэг, дадлыг хамгаалах зорилгоор уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байх тусгай санхүүжилт хуваарилах. Нүүдлийн мал аж ахуйн соёлын өвд малчдын үеэс үед хөгжүүлж, арчилж ирсэн тэжээвэр мал, амьтны биологийн төрөл зүйлийн олон янз байдалтай

холбоотой уламжлалт мэдлэг мөн хамаарна. Малын үүлдрийн олон янз байдал, генетикийн нөөц нь соёлын өв бөгөөд мэдлэгийн сан хөмрөг, мөн нэмэлт шууд санхүүжилт шаардлагатай экологийн хөрөнгө юм.

6. Бодлогоор чулуужсан түлшид хамааралтай, эрчимжсэн мал ахуйн салбарт олгодог урамшууллыг хязгаарлаж давуу эрх олгохоо зогсоох. Зах зээлийн оролцоо нь суурьшил, үйлдвэрлэлийн эрчимжилт, мал амьтны үүлдрийн стандартчилал эсвэл бэлчээрийг хуваах, жижиглэхэд хүргэх бус, малчдын мал ахуйгаа эрхлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэхийн тулд мал аж ахуйн зах зээл, хөрөнгө оруулалт, өртгийн сүлжээний хөгжлийг зохицуулах шаардлагатай.
7. Малчдад уур амьсгалын хяналт шинжилгээ хийх эрх мэдэл олгож, зөвхөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицуулах бодлогын оролцогч гэж үзэлгүй, түүний хамтран гүйцэтгэгч хэмээн үзэж, тэдгээрийн ажиглалт, уламжлалт мэдлэгийг ашиглан хяналт шинжилгээний үндэс болгон соёлын өвийг тээгчдийг хүндэтгэх.
8. Залуу малчид, өвийн эзэдтэй хамтран хөрөнгө оруулж, тэднийг нутаг орны ирээдүйн эзэн хэмээн үзэж, нүүдлийн мал аж ахуйгаас хот руу шилжихэд хүргэж буй нөхцөл байдлыг шийдвэрлэх, үе дамжих явцад тасалдсан нүүдлийн уламжлалыг зөвхөн санхүүжилтээр сэргээх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх.
9. Онгон дагшин газар нутаг, соёлын дурсгалт газар, биет соёлын өвийг хамгаалахад хөрөнгө оруулах бөгөөд малчдыг энэхүү соёлын өвийг хамгаалагч гол этгээд хэмээн шууд санхүүжүүлэх холбоо бий болгох. Соёл ба байгалийн үнэт зүйл нягт холбогдсон газар оронд болон бусад газарт нөлөөллийн үнэлгээ хийх.[16]
10. Уул уурхай, газар тариалан, химийн бохирдол, хог хаягдал зэргээр бэлчээр-нүүдлийн замыг устгаж, бохирдуулж, доройтуулсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тогтолцоо бий болгох. “Бохирдуулагч нь төлөх” зарчмыг баримталж, тухайн этгээдээс бохирдлыг цэвэрлэж, сүйтгэсэн газар орныг сэргээж, хүн, мал, бэлчээрт учирсан эрүүл мэндийн хохирлыг төлүүлэхийг шаардах.

Нүүдэлчин малчид ба тэдний амьдрах нутаг дэвсгэр, усны эх, ариун дагшин газар, нүүдлийн зам хоорондын харилцаа соёлын эрх хэмээн хүлээн зөвшөөрөгдөж, хамгаалагдах ёстой. Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй нь тусдаа зүйл биш; энэ бол нүүдэл ба хувьсанги байдлын харилцан үйлчлэлээс шалтгаалан хамтдаа хувьсан хөгждөг тогтолцоо юм. Энэхүү тогтолцоог тэтгэж байдаг нүүдэл суудлыг хязгаарлах замаар газрын нөхөн сэргээлтийг санхүүжүүлэх нь НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын эрмэлзэж буй үр дүнгийн эсрэг ажиллаж буй хэрэг юм.

Бид Талуудад газрыг тордон хамгаалах нь хууль журам бөгөөд малчдын нүүдэл нь энэхүү арчилгааны хамгийн эртний хэлбэрүүдийн нэг гэдгийг сануулахыг хүсэж байна. Нүүдлийн мал аж ахуйг өөрийн нь нөхцөлд тэтгэн дэмжих нь цөлжилттэй тэмцэхээс ухарч буй хэрэг биш энэ бол түүнд хүрэх хамгийн дөт замуудын нэг юм.

*“Нүүдлийн ирээдүй: Соёлын эрх, мэдлэгийн тогтолцоо, уур амьсгалын өөрчлөлтийг сөрөн тэсвэрлэхүй” хурлын оролцогчдын нэрийн өмнөөс өргөн барив.*

**Зохиогчид**

Айза Абдырахманова, Айгине соёлын судалгааны төв, Киргиз; Ариелль Ахерн, Оксфордын их сургууль, Газар зүйн сургууль; Курбонидин Аламшоев, Бүгд Найрамдах Тажикистан Улсын Соёл, мэдээллийн хүрээлэн; Гэрэлмаа Алтангэрэл, Канберрагийн их сургууль, Боловсролын факультет, Австрали; Мээрим Айткеева, Айгине соёлын судалгааны төв, Киргиз; Васси Берхану, Аддис-Абебагийн их сургууль, Этиоп; Сумъяа Билэгсайхан Тайж, Бие даасан судлаач; Оюун-Эрдэнэ Чулуунбаатар, Чианг Майн их сургууль, Төрийн бодлогын сургууль; Жеймс Коррейа, Азийн хөгжлийн банк (АХБ); Франсиска Кортес Кесада, Чилийн Автономит их сургууль; Сесилия Даль Зово, Оксфордын их сургууль, Археологийн сургууль; Юаньхуй Дин, Бие даасан судлаач; Анужин Эрдэнэбаяр, Ой Херитаж (OI HERITAGE); Тамир Эрдэнэчулуун, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улс; Тамир Эрдэнэцогт, Ворд Медиа ХХК; Ханде Синем Эргүн, Мармара их сургууль,

Турк; Наташа Фийн, Австралийн үндэсний их сургууль; Брюс Форбс, Лапландын их сургууль, Арктикийн төв, Финлянд; Юфан Гао, Йелийн их сургууль, Интер-Ази санаачилга; Радхика Гупта, Before More is Lost; Кармен Хамел, Альбертагийн их сургууль; Чиеко Хирота, Японы шинжлэх ухааныг дэмжих нийгэмлэг (JSPS) / Австралийн үндэсний их сургууль; Балжинням Ишгэн, Утааны эсрэг ээж аавууд / Breathe Mongolia ТББ; Долгорсүрэн Жамъян, Сити их сургууль, Монгол Улс; Акира Камимура, Токиогийн гадаад судлалын их сургууль, Япон; Мари Казато, Хокусэй Гакуэн их сургууль / Токиогийн гадаад судлалын их сургууль, Япон; Вахид Хан, Оксфордын их сургууль; Оюундэлгэр Хүрэлпүрэв, Зенкенбергийн байгаль судлалын нийгэмлэг; Ильзе Кёлер-Роллефсон, Малчин ард түмний холбоо; Шинья Конака, Шизуокагийн их сургууль, Япон; Саверио Кратли, Олон улсын антропологи, угсаатны зүйн шинжлэх ухааны холбоо (IUAES) — Нүүдэлчин ард түмний комисс; Сара Луначек, Люблянагийн их сургууль, Словени; Ганжаргал М., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль; Малахат Мазинани, Ираны Байгалийн нөөц, усны сав газрын менежментийн байгууллага; Даниел Ж. Мерфи, Цинциннатийн их сургууль, АНУ; Оюундалай Одхүү, Үндэсний Ченчи их сургууль, Тайвань; Руона Чи, Дюкийн их сургууль; Брэдли Раппа, Итака коллеж; Хатансайхан Равдандорж, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улс; Жоана Роке де Пиньо, Олон улсын судалгааны төв (CEI-Iscte), Португал; Перегрин Ротман-Остроу, Кембрижийн их сургууль; Мижид Сайнбуян, Масарикийн их сургууль; Мериам Сехими, Делфтийн технологийн их сургууль (TU Delft); Бямба Шараа, Монгол Улсын Их Сургууль; Номинбаясгалан Сүлд, Монголын криминологийн нийгэмлэг; Женни Тан, Кембрижийн их сургууль; Моэ Терао, Канто Гакуин их сургууль; Эрик Трифт, Виннипегийн их сургууль, Канад; Сяозе Тянь, Цукубагийн их сургууль; Лхагвадулам Төмөр-Очир, Монгол Улсын Соёл урлагийн их сургууль; Тунгалаг Уламбаяр, Луужин амьтан судлалын нийгэмлэг; Каролин Аптон, Лестерийн их сургууль, Их Британи; Кристофер Нельсон Визда, Бие даасан судлаач; Ганболд Яндаг, Мал эмнэлгийн фармакологийн хүрээлэн ТББ; Сарантуяа Зандаръяа, ЮНЕСКО-ийн Усны шинжлэх ухааны хэлтэс / Засгийн

газар хоорондын ус судлалын хөтөлбөр (IHP); Анна Лэйк Жу, Вагенингений их сургууль; Бум-Очир Дулам, Монгол Улсын Их Сургууль; Түвшинтөр Мөнхтүмэн, Малчин; Фернандо Гарсиа-Дори, Дэлхийн нүүдэлчин уугуул иргэд ба малчдын холбоо (WAMIP); Бямбажаргал Аюушжав, Цинхуа их сургууль; Цэнгүүн Ганбат, Сити их сургууль; Баярсайхан Намсрай, Хилгүй алхам ТББ; Болдбаатар Нямсүрэн, Малчин; Молу Кулу, Оюун санааны удирдагч; Хуссейн Исак, Кивулини Траст; Гуфу Ибраэ Али, Дэлхийн уугуул оюун санааны зүтгэлтнүүдийн холбоо; Буянбадрах Эрдэнэцогт, Дэлхийн уугуул оюун санааны зүтгэлтнүүдийн холбоо; Миррахим Опош, Уран бүтээлч, Киргиз; Айбек Байымбетов, Төв Азийн их сургууль; Тунга Рай, Балбын Уугуул үндэстнүүдийн холбоо (NEFIN); Золжаргал Энхамгалан, Кембрижийн их сургууль; Мөнхтамир Дамдинсүрэн, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн; Анужин Бат-Эрдэнэ, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн; Батбуян Батжав, Нүүдлийн мал аж ахуйг судлах төв; Дэлгэрзаяа Дэлгэржаргал, Ройтерс (Reuters); Ханд Бямбаа, Малчин; Орхон Мядар, Хавайн их сургууль; Дон Чатти, Оксфордын их сургууль; Мөнхтуул Чулуунбаатар, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн

**Тэмдэглэл**

1. НҮБ-ын Нүүдэлч уугуул иргэдийн асуудал хариуцсан тусгай илтгэгчийн тайлан (2024) https://www.ohchr.org/en/documents/thematic-reports/a79160-report-special-rapporteur-rights-indigenous-peoples-jose
2. League for Pastoralist Peoples (2024) https://www.pastoralpeoples.org/international-workshop-on-camelid-pastoralism/
3. Соёлын эрхийн тухай Фрибургийн тунхаглал (2007) https://www.unifr.ch/ethique/fr/assets/public/Files/declaration-eng4.pdf

4. ЮНЕСКО-ийн Соёлын олон төрөл зүйлийн тухай түгээмэл тунхаглал (2001) https://www.unesco.org/en/legal-affairs/unesco-universal-declaration-cultural-diversity

5. Нүүдэлчид ба байгаль хамгааллын тухай Дана тунхаглал (2002) https://danadeclaration.org/dana-declaration/

6. Дана манифест 20+ (2022) https://danadeclaration.org/dana-20-manifesto/

7. Нүүдэлчдийн ёс зүй ба соёл хоорондын яриа хэлэлцээний тухай мэдэгдэл (2024) https://doi.org/10.67086/nsj.31.29

8. Залуу малчдын дэлхийн тунхаглал (2026) https://iyrp.info/sites/default/files/documents/Declaration-ENG-Young-Pastoralists-short-version.pdf

9. Малчин эмэгтэйчүүдийн Катманду тунхаглал (2026) https://iyrp.info/sites/default/files/2026-08/Kathmandu-Declaration-Accepted-8-Aug-rev-15-Aug-highlights-removed.pdf

10. Тогтвортой бэлчээрийн эрхийн төлөөх нүүдэлчдийн улаан шугам санаачилга (2026) https://www.wamaalliance.org/post/nomads-red-line-initiative-for-sustainable-pasture-rights

11. ЮНЕСКО-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт. https://ich.unesco.org/en/lists

12. IYRP-ийн бодлогын товч (2025). Мал аж ахуйн хувьд уур амьсгалын бодлогыг эргэн харах нь. https://iyrp.info/sites/default/files/2025-11/Policy-brief-Pastoralists-and-Climate-change_Final01112025_0.pdf

13. Санхүүжилтийн боломжит эх үүсвэрт Дэлхийн байгаль орчны сан (GEF), Уур амьсгалын ногоон сан (GCF), Газрын доройтлыг саармагжуулах (LDN) сан болон бусад олон улсын болон бүс нутгийн санхүүжилтийн механизмууд багтана.

14. Мөн үзнэ үү: Rights and Resources Initiative (2026) Rights on the Move: A Practical Reform Guide on the Rights of Pastoralists and Mobile Peoples

[Малчид болон нүүдлийн ард түмний эрхийн талаарх практик шинэтгэлийн удирдамж]. https://rightsandresources.org/publication/rights-on-the-move/

15. *Оюун санааны нөлөөллийн үнэлгээ* гэдэг нь санал болгож буй төсөл эсхүл газар ашиглалтын өөрчлөлт нь нийгэмлэгийн газар нутагтай холбоотой харилцаанд, тухайлбал ариун газар, өвөг дээдсийн холбоо, зан үйл, ёслол, мөн газар нутаг болон нүүдэл хөдөлгөөнтэй салшгүй холбоотой оюун санааны болон уламжлалт мэдлэгийг үеэс үед өвлүүлэн залгамжлуулахад хэрхэн нөлөөлж байгааг, мөн нийгэмлэгийн оюун санааны эрх чөлөө, тэсвэрлэх чадварыг бэхжүүлж байгаа эсэх, эсхүл сулруулж байгаа эсэхийг дүгнэн үнэлэхийг хэлнэ.
16. Дэлхийн өвийн хүрээн дэх нөлөөллийн үнэлгээний талаарх ЮНЕСКО-ийн удирдамж, https://whc.unesco.org/en/guidance-toolkit-impact-assessments/